



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 40


Улаанбаатар хот

- Г Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханд даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Т.МӨНХСАЙХАН

Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

### 1.1. Оршил

Эрүүл мэндийн яам /цаашид “яам” гэх/-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид “хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/ болон Эрүүл мэндийн сайд /цаашид “сайд” гэх/-ын эрхлэх асуудлын хүрээнд салбарын хөгжлийн бодлого, стратегийг оновчтой тодорхойлох, хууль тогтоомж, шийдвэрийн төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтэд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлж үр дүнд нь үнэлгээ өгч, дүгнэлт зөвлөмж гаргах асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүргийг тодорхойлоход оршино.

### 1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэслэн боловсруулав.

### 1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг доор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;

-Захиргааны ерөнхий хууль;

-Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;

-Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;

-Төсвийн тухай хууль;

-Төрийн албаны тухай хууль;

-Хөдөлмөрийн тухай хууль;

-Эрүүл мэндийн тухай хууль;

-Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль;

-Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль;

-Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;

-“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;

-Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал;

-Холбогдох бусад хууль тогтоомж.

#### 1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад бодлого, төлөвлөлт, хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, өмнө хэрэгжсэн хөтөлбөрүүдийн ололт, сургамжид үндэслэн оролцооны аргыг ашиглалаа. Мөн салбарын тулгамдаж байгаа асуудал, тэргүүлэх чиглэл, стратеги, үйл ажиллагааны зорилтуудыг харгалзан онол, арга зүй, олон улсын туршлага зэрэг бүтцийн нэгжийн чиг үүргийг тодорхойлоход хэрэглэдэг арга зүйг ашиглав.

#### 1.5. Яамны үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь


Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд бодлого, стратеги, хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээж, сайд болон Засгийн газрын танхимд салбарын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн бүх талын дэмжлэг үзүүлнэ. Сайдын эрхлэх хүрээний аливаа асуудалд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой зохицуулалтаар удирдана.

#### 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч

Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр нь үйлчлүүлэгч бөгөөд нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой, бүрэн тодорхойлох нь яамны үйл ажиллагааны стратегийг тогтооход чухал ач

холбогдолтойг харгалзан хэрэгцээний эх үүсвэрт дараах үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг хамруулав.

### Эрүүл мэндийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



#### 1.7. Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч

Яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь сайд, Засгийн газрын танхим байна. Яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон, тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги болон төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

#### Хоёр. Үйл ажиллагааны стратеги

##### 2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлснээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн бүрд чанартай, аюулгүй, хүртээмжтэй хүргэж, амьдралын чанарыг сайжруулан, хүн амын дундаж наслалтыг уртасгахад чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохицуулахад оршино.

## 2.2.Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Яам нь үйл ажиллагааны доор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1.эрүүл мэндийн нэгдсэн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.2.2.эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх салбарын оновчтой, чадварлаг бүтцийг бүрдүүлж, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;

2.2.3.нээлттэй, ил тод, шуурхай үйлчилгээ үзүүлэх.

## 2.3.Үйл ажиллагааны эрхэм зорилго

Яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүртээмжтэй, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг иргэн бүрд хүргэж, амьдралын чанарыг нь сайжруулснаар хүн амын дундаж наслалтыг уртасгахад оршино.

## 2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт

Яам нь эрхэм зорилгынхoo хүрээнд үйл ажиллагааны доор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1.эрүүл мэндийн салбарын нэгдсэн төлөвлөлт-стратеги, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөц, цахим эрүүл мэндтэй холбоотой хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;

2.4.2.нийгийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эрт илрүүлэх арга хэмжээтэй холбоотой хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;

2.4.3.иргэдэд эмнэлгийн тусlamж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй, чанартай тусlamж үйлчилгээ үзүүлэх чиг үүргийн хүрээнд хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, анааах ухааны инновац, техник, технологийг хөгжүүлж, үр дүнг практикт нэвтрүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;

2.4.4.төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн талаарх хууль тогтоомжид судалгаа, шинжилгээ хийх, боловсронгуй болгох, сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;

2.4.5.эрүүл мэндийн салбарын төсөв, хөрөнгө оруулалт, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, санхүүгийн нэгдсэн төлөвлөлт, шаардлагатай тооцоо судалгаа хийх, тэдгээртэй холбоотой хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;

2.4.6.хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт болон сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгч, хэрэгжилтийг ханглуулах;

2.4.7.эрүүл мэндийн байгууллага болон бусад байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сайдын эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт хийх, чанар, аюулгүй байдал, эрсдэлийн түвшин тогтоох, бууруулах арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах.

## 2.5.Үйл ажиллагааны зорилт

2.5.1.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1.салбарын нэгдсэн төлөвлөлт, стратеги боловсруулах, хэрэгжилтийг бодлогын нэгдсэн арга зүйгээр хангах;

2.5.1.2.төр, хувийн хэвшилийн түншлэлийн бодлого боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах;

2.5.1.3.салбарын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн төлөвлөлт боловсруулах, хэрэгжилтийг бодлогын нэгдсэн арга зүйгээр хангах;

2.5.1.4.эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн эрх зүйн орчныг сайжруулах, бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.1.5.эм, эмнэлгийн хэрэгслийн талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.1.6.салбарын удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим эрүүл мэндийн талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг хангах.

2.5.2.Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.2.2.гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үед нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, хариу арга хэмжээ авах, эрсдэлийн үеийн харилцаа холбоог удирдах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

2.5.2.3.нийгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрх зүйн акт, стандарт, заавар боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах;

2.5.2.4.нийгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүний эрх тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон хүүхдийн эрх, жендерийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах;

2.5.2.5.нийгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, тайлагнах;

2.5.2.6.нийгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг төлөвлөх, уялдааг хангах, зохицуулах.

2.5.3.Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1.эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.3.2.эмнэлгийн тусламж, үйлчилгээний эрх зүйн акт, стандарт, эмнэл зүйн зааврыг боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах;

2.5.3.3.эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах бодлого боловсруулах, төлөвлөх, үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах;

2.5.3.4.мэргэжлийн салбар зөвлөл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, тогтоомж, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

2.5.3.5.эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хүний эрх тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон хүүхдийн эрх, жендерийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах;

2.5.3.6.эмнэлгийн тусламж, үйлчилгээнд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, тайлагнах;

2.5.3.7.эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр салбар болон шатлал хоорондын хамтын ажиллагааг хангах, зохицуулах;

2.5.3.8.судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг салбарын бодлогод нийцүүлэн боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

2.5.3.9.эрүүл мэндийн техник, технологи, технологийн үнэлгээ, инновациын бодлого боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах.

#### 2.5.4.Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1.төрийн захиргааны албыг шуурхай удирдан, яамны дотоод ажлыг төлөвлөн оновчтой зохион байгуулах;

2.5.4.2.салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг зохицуулалтаар хангах;

2.5.4.3.яамны хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг хангах;

2.5.4.4.хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн талаарх хууль тогтоомжид судалгаа, шинжилгээ хийх, төлөвлөх, боловсронгуй болгох;

2.5.4.5.харьяа эрүүл мэндийн байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулах, байгууллагын дүрэм, бүтэц, стратеги төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах;

2.5.4.6.төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

2.5.4.7.яамны албан хаагчдын болон харьяа байгууллагын удирдах ажилтны хөдөлмөрийн харилцааг зохицуулах;

2.5.4.8.яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах.

#### 2.5.5.Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1.эрүүл мэндийн эдийн засаг, эрүүл мэндийн даатгал, санхүү, хөрөнгө оруулалт, цалин хөлсний бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах;

2.5.5.2.эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, төлбөртэй тусlamж үйлчилгээ, тусlamж үйлчилгээний багц тодорхойлох бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах;

2.5.5.3.төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах;

2.5.5.4.төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, тайлагнах;

2.5.5.5.эрүүл мэндийг дэмжих сан, гадаадын зээл, тусlamжийн төсвийг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах;

2.5.5.6.төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн төлбөр тооцоог хийх;

2.5.5.7.салбарын хэмжээнд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;

2.5.5.8.салбарын үндэсний тооцоолол хийх.

2.5.6.Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1.сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах;

2.5.6.2.сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хяналт шалгалт хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдүүлэх;

2.5.6.3.хууль тогтоомж, салбарын бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, арга хэмжээ, зээл, тусlamжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүн, үр нөлөөний үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах;

2.5.6.4.сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх.

2.5.7.Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.5.7.1.сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хяналт шалгалт хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдүүлэх;

2.5.7.2.сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болон бусад байгууллагад эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шалгалтыг гүйцэтгэх, салбарын эрсдэлийн удирдлагыг нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалтаар хангах;

2.5.7.3.гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үеийн хяналт шалгалтын удирдлага, төлөвлөлт, зохицуулалт хийх;

2.5.7.4.эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх, нэгдсэн буртгэл, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах;

2.5.7.5.салбарын улсын байцаагчдыг мэргэжлийн арга зүй, шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангах.

#### 2.6.Үйл ажиллагааны зорилт

Яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

#### 2.7.Үйл ажиллагааны стратегийн загвар

Яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг доор дурдсанаар тодорхойлж байна.

## Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратегийн загвар

Эрхэм зорилго	Стратегийн зорилт	Үйл ажиллагааны зорилт
<p>Хүртээмжтэй, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг иргэн бүрд хүргж, амьдралын чанарыг нь сайжруулснаар хүн амын дундаж наслалтыг уртасгахад оршино.</p>	<p>Эрүүл мэндийн салбарын нэгдсэн төлөвлөлт, стратеги, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөц, цахим эрүүл мэндийг хөгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;</p>	<p>-салбарын нэгдсэн төлөвлөлт, стратеги боловсруулах, хэрэгжилтийг бодлогын нэгдсэн арга зүйгээр хангах; -төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах; -Салбарын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн төлөвлөлт боловсруулах, хэрэгжилтийг бодлогын нэгдсэн арга зүйгээр хангах -эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн талаарх эрх зүйн орчныг сайжруулах, бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтийг хангах; -эм, эмнэлгийн хэрэгслийн талаарх хууль, тогтоомж, бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтийг хангах; -салбарын удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим эрүүл мэндийн талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох бодлого боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах.</p>
<p>Иргэдэд эмнэлгийн тусlamж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй авах, чанартай тусlamж үйлчилгээ үзүүлэх чигүүргийн хүрээнд хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах.</p>	<p>Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчинеес урьдчилан сэргийлэх, хянах, эрт илрүүлэх арга хэмжээтэй холбоотой хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах.</p>	<p>-нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний бодлого, хууль тогтоомж боловсруулах, төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтийг хангах; -гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үед нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, хариу арга хэмжээ авах, эрсдэлийн үеийн харилцаа холбоог удирдах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах; -нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний эрх зүйн акт, стандарт, зааврыг боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах; -нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд хүний эрх тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон хүүхдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах; -нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, тайлгаха; нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг төлөвлөх, уялдааг хангах, зохицуулах.</p>
<p>Иргэдэд эмнэлгийн тусlamж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй авах, чанартай тусlamж үйлчилгээ үзүүлэх чигүүргийн хүрээнд хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, анагаах ухааны инноваци, технологийг хөгжүүлж, үр дүнг практикт нэвтрүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах.</p>	<p>Иргэдэд эмнэлгийн тусlamж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй авах, чанартай тусlamж үйлчилгээ үзүүлэх чигүүргийн хүрээнд хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, анагаах ухааны инноваци, технологийг хөгжүүлж, үр дүнг практикт нэвтрүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах.</p>	<p>-эмнэлгийн тусlamж, үйлчилгээний бодлого, хууль тогтоомж боловсруулах, төлөвлөх, зохицуулах, хэрэгжилтийг хангах; -эмнэлгийн тусlamж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн заавар боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах; -эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл, тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах бодлого боловсруулж, үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах; -мэргэжлийн салбар зөвлөл, эмнэлгийн мэргэжилтийн ёс зүйн хяналтын хорооны үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн ажилнуудад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах; -эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд хүний эрх тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон хүүхдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах; -эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, тайлгаха; -эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чиглэлээр салбар болон шатлал хоорондын хамтын ажиллагааг төлөвлөх, хангах, зохицуулах; -судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг салбарын бодлогод нийцүүлэн боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах; -эрүүл мэндийн техник, технологи, инноваци, технологийн үнэлгээний бодлого боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах.</p>

Хүртээмжтэй, чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг иргэн бүрт хүргэх, амьдралын чанарыг нь сайжруулснаар хүн амын дундаж наслалтыг уртасгахад оршино.

Төрийн захирагааны удирдлагын манлайллыг хангаж, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн талаарх хууль тогтоомжид судалгаа, шинжилгээ хийх, боловсронгуй болгох, сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж ёгч, хэрэгжилтийн хангуулах.

Эрүүл мэндийн салбарын төсөв, хөрөнгө оруулалт, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэр нэмэгдүүлэх, санхүүгийн нэгдсэн төлвлөлт, шаардлагатай тооцоо судалгаа хийх зэрэгтэй холбоотой хууль тогтоомж, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого хөтөлбөр, төлвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;

- терийн захирагааны албыг шуурхай удирдан, яамны дотоод ажлыг оновчтой төлөвлөн зохион байгуулах;
- салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг зохицуулалтаар хангах;
- яамны хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны бодлого, зохицуулалт, хэрэгжилтийг хангах;
- хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн талаарх хууль тогтоомжид судалгаа, шинжилгээ хийх, боловсронгуй болгох;
- харьяа эрүүл мэндийн байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулах, байгууллагын стратеги, дүрэм, бүтэц, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах;
- терийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- яамны албан хаагчдын болон харьяа байгууллагын удирдах ажилтны хөдөлмөрийн харилцааг зохицуулах;
- яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах.

- сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулах, аргачлалын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах;
- хууль тогтоомж, салбарын бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, арга хэмжээ, зээл, тусlamжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүн, үр нөлөөний үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах;
- сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудит хийх.

- эрүүл мэндийн эдийн засаг, эрүүл мэндийн даатгал, санхүү, хөрөнгө оруулалт, цалин хөлслний бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах;
- эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, төлбөртэй тусlamж үйлчилгээ, тусlamж үйлчилгээний бағц тодорхойлох бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах;
- төсвийн ерөнхийлөн захирагчийн үргсл болон хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах;
- төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, тайлагнах;
- эрүүл мэндийг дэмжих сан, гадаадын зээл, тусlamжийн төсвийг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах;
- төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн төлбөр тооцоог хийх;
- салбарын хэмжээнд шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;
- салбарын үндэсний тооцоолол хийх.

Хүртээмжтэй,  
чанартай,  
аюулгүй эрүүл  
мэндийн  
тусlamж,  
үйлчилгээг  
иргэн бүрт  
хүргэж,  
амьдралын  
чанарыг нь  
сайжруулнаар  
хүн амын  
дундаж  
наслалтыг  
уртасгахад  
оршино.

Эрүүл мэндийн байгууллага  
болон бусад байгууллага, аж  
ахуйн нэгжүүдэд сайдын  
эрхлэх асуудлын хүрээнд  
хяналт шалгалт хийх, чанар,  
аюулгүй байдал, эрсдэлийн  
түвшин тогтоох, бууруулах  
арга хэмжээг нэгдсэн  
удирдлага, зохион  
байгуулалтаар хангах.

-сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хяналт  
шалгалт хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг  
боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн  
хэрэгжилтийг мөрдүүлэх;  
-сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болон бусад  
байгууллагад эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ, хууль  
тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шалгалтыг гүйцэтгэх,  
салбарын эрсдэлийн удирдлагыг нэгдсэн зохион байгуулалт,  
зохицуулалтаар хангах, салбарын улсын байцаагчдыг  
мэргэжлийн арга зүй, шуурхай удирдлага, зохион  
байгуулалтаар хангах;  
-эмнэлгийн тусlamж, үйлчилгээтэй холбоотой чанар, аюулгүй  
байдалд хяналт шалгалт хийж, гомдлыг шийдвэрлэх, нэгдсэн  
бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах  
зохицуулах;  
-Гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үеийн  
хяналт шалгалтын удирдлага, төлөвлөлт, зохицуулалт хийх.

Гурав. Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо,  
зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн  
үндсэн үүрэг, чиг үүрэг

### 3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим

Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав.

3.1.1. яамны стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (яамны үйл ажиллагааны бүтцийн тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2. эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх);

3.1.3. үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, яамны бүтэц, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4. бүтцийн хувьд энгийн байх зарчим (яамны Төрийн нарийн бичгийн даргаас албан хаагч хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5. тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болох оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүний болон бусад нөөцийг зөв хуваарилан, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байх);

3.1.6. мэргэшсэн байх зарчим (тухайн яамны албан хаагч нь эрхэлсэн сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчид мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан байх);

3.1.7. хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

### 3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон яамны үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дараах тогтолцооны ерөнхий загварыг санал болгож байна:

### Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны бүтцийн тогтолцооны ерөнхий загвар



### 3.3. Зохион байгуулалтын бүтэц

Яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварт дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд дараах үндсэн үүрэг, чиг үүрэгтэй:

3.3.1. Стратеги төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:

Тус нэгж нь стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд салбарын нэгдсэн төлөвлөлтийг боловсруулах, бодлогын нэгдсэн арга зүйгээр хангах, салбарын хүний нөөцийн хөгжил, эм, эмнэлгийн хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэл, салбарын бүсчилсэн хөгжил, удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим мэдээллийн бодлого, төлөвлөлт, эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг тусlamж, үйлчилгээний бодлоготой уялдуулан төлөвлөх, тусгай зөвшөөрөл олгох, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамtran ажиллах гэрээ байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд салбарын хүний нөөцийн хөгжлийн нэгж, эрүүл мэндийн мэдээлэл, цахим хөгжлийн нэгж, эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын нэгж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

**3.3.2. Нийгмийн эрүүл мэндийн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:**

Тус нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, хууль тогтоомж, эрх зүйн акт, стандарт, заавар боловсруулах, төлөвлөх, зохицуулах ажлыг зохион байгуулах, Олон Улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах, гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, тандах, бэлэн байдлыг хангах, эрсдэлийн үеийн мэдээ, мэдээлэл, харилцаа холбоо, хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн арга хэмжээг зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг зохицуулах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд халдварт өвчний нэгж, халдварт бус өвчний нэгж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

**3.3.3. Эмнэлгийн тусламжийн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:**

Тус нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд хүн амд хүртээмжтэй, чанартай, аюулгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, мэргэжлийн салбар зөвлөл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд анагаах ухааны дэвшилтэй технологийг нэвтрүүлэх ажлыг нэгдсэн арга зүйгээр хангах, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эрх зүйн акт, стандарт, зааврыг боловсруулах, шинэчлэх, мөрдүүлэх, анагаахын шинжлэх ухааны судалгаа, нэвтрүүлэх технологийн тэргүүлэх чиглэлийг төлөвлөх, үр дүчг нэвтрүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хүний эрх тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан бопон хувьлийн эрх жэнлэрийн тэгш байлпыг хангах чадлыг ажиллагааг зохион

байгуулах, зохицуулах, эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, гадаад оронд тусlamж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн эмчилгээний асуудлыг зохицуулах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд анхан болон лавлагаа шатлалын тусlamжийн нэгж, анагаах ухааны инновац, технологийн нэгжтэй нэгж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

**3.3.4.Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:**

Тус нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд төрийн захиргааны болон яамны хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, хүний нөөцийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, дүрэм, бүтэц, стратеги төлөвлөгөө, боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, тайлагнах, яамны албан хаагчдын нийгмийн хамгааллын болон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж, эрх зүйн зөвлөгөө үзүүлэх, яамны нэгжүүдийн үйл ажиллагааны уялдааг хангах, ажилтнуудын ажиллах тав тухтай орчин бүрдүүлэх, авлигын эсрэг болон нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн давхардал хийдлийг хянах, эрүүл мэндийн талаарх хууль тогтоомжид судалгаа, шинжилгээ хийх, боловсронгуй болгох үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд хуулийн нэгж, гадаад хамтын ажиллагааны нэгж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

**3.3.5.Санхүү, эдийн засгийн бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:**

Тус нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд салбарын элийн засаг санхүү энчилж мэнлийн пяатгап хөрөнгө оруулж

цалин хөлсний бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжилт, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, төлбөртэй тусlamж, үйлчилгээний санхүүжилтийн бодлого боловсруулах, гадаадын зээл, тусlamжийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, биелэлтийг хангуулах, тайлагнах, эрүүл мэндийг дэмжих сан, гадаадын зээл, тусlamжийн төсвийг төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах, салбарын үндэсний тооцоолол, улсын төсвийн санхүүжилтийн уялдаа холбоог хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалтын нэгж, санхүү, даатгалын нэгж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

**3.3.6.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:**

Тус нэгж нь үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, зээл, тусlamжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх, хуульд заасны дагуу санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

**3.3.7.Салбарын хяналтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг:**

Тус нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шинэ арга аргачлалыг нэвтрүүлэх, салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, салбарын хяналт шалгалтын эрсдэлийн ангилал, шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн төлөвлөх, зохион байгуулах, зөвлөн туслах, хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, иргэд, байгууллагаас ирсэн тусlamж, үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн төрийн болон

хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

---оо---

